


Ээлжит хичээлийн сэдэв:
Жинхэнэ нэрийн утга, бүтэц
Ээлжит хичээлийн зорилго:
Жинхэнэ нэрийн утга, бүтцийг
онцлогийг таньж, хэрэглэх

НЭГЖ СЭДЭВ: ЖИНХЭНЭ НЭР

Үгийн аймгийн тухай онолын ойлголтыг дэвтэртээ бичээрэй.



Алхам 1. Эхийг анхааралтай уншаарай.



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ.

Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ “Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно.” гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас

ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. “Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа.” гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.

Алхам 2: Дээрх эхэд тодруулсан жинхэнэ нэрийн жишээнд харгалзах утгыг өнгөөр хүрээлж будаарай.




Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ.


Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ “Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно.” гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас

ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. “Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа.” гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.



Өгсөн асуултад хариулагдах үгсийг эхээс түүж бичээрэй.



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ.

Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ "Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно." гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас

ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ.


"Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа." гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.

А. Хэн?

В. Юу?

Алхам 4: Бүдүүвч дэх ерийн нэрийн өмнө оноосон нэр бичээд, дүрмийг тайлбарлаарай.



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ. Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ “Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно.” гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. “Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа.” гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ. Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.

Жинхэнэ нэрийн утга	
Оноосон нэр	Ерийн нэр
Доной.....	өвгөн
.....	хөвгүүд
.....	уул

Алхам 4: Дээрх эхэд тодруулсан зарим үгийг үүсмэл ба үүсмэл бишээр нь ялгаж харууллаа.

А. Жишээг ажиглаж, ялгааг ойлгоорой.

Б. Үүсмэл жинхэнэ нэрийг язгуур, дагавраар зааглаж бичээрэй.



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт **ухаанаас** өөр **өв хөрөнгөгүй** нэгэн **өвгөн** амьдарч байжээ. Нэгэн өдөр өвгөн долоон **хүүдээ** “Их **гэрийн** **үлгэрээр** бага **гэрийг** барьж болно.” гэж ярихад **хөвгүүд нь** **учрыг** олсонгүй өнгөрчээ. **Өвгөн** хүрээлсэн **эргэн тойрны уулсыг** дуурайлган бургасан **хана** хийв. Цасан **шуурганд** хаагддаг, **цагийн** сайханд нээгддэг **нарнаас тооно**, тал тал тийш урссан алтан **цацрагуудаас** унь, **уулын** араас ургасан **манан будангаас туурга**, дээгүүр бүрхсэн зузаан **үүлсээс дээвэр** хийх **санаа** олжээ. “Түшилдэн ханхайсан **уул нуруунуудын** араар хүрдэн **салхи** эрчлэн эргэж байгаа даа.” гэж бодуутаа **хялгас** томж, **бүслүүр** хийв. Тэгээд **өвгөн** долоон **хүүтэйгээ ханаа** дэлгэж, **хаалгаа** босгож, **тооноо** өргөж, **униа** өлгөж, **туургаа** барьж, **дээврээ** тавьж, **бүслүүрээ** татаад, бөмбөрцөг **дэлхийн хэлбэртэй** бөмбөгөр цагаан **гэртэй** болов гэнэ. Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай **гэр** бүтээсэн **эцгийнхээ ухааныг хөвгүүд нь** биширч, ая тавтай аж төрөх болжээ.

Жинхэнэ нэр бүтэх ёс		
	Үүсмэл	Үүсмэл биш
Дагаврын аргаар бүтсэн (Үгийн язгуур үндсэнд дагавар залгаж бүтнэ.)	Үг нийлэх аргаар бүтсэн (Хоёр өөр үг нийлж 1 юмыг нэрлэнэ.)	өвгөн гэр дэлхий
ухаан = ух+аан	өв хөрөнгө	хүү
шуурга =	эргэн тойрон	үлгэр
цацраг =..... ...	манан будан	учир
дээвэр =	уул нуруу	уул



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ.


Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ "Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно." гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас

ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. "Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа." гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.


Жинхэнэ нэр бүтэх ёс		
	Үүсмэл	Үүсмэл биш
Дагаврын аргаар бүтсэн (Үгийн язгуур үндсэнд дагавар залгаж бүтнэ.)	Үг нийлэх аргаар бүтсэн (Хоёр өөр үг нийлж 1 юмыг нэрлэнэ.)	өвгөн гэр дэлхий
ухаан = ух+аан	өв хөрөнгө	хүү
шуурга =	эргэн тойрон	үлгэр
цацраг =..... ...	манан будан	учир
дээвэр =	уул нуруу	уул

Алхам 5: Дараах өгүүлбэрт өгүүлэгдэж байгаа юмсыг заасан жинхэнэ нэр ямар үгтэй холбогдож байгааг тодорхойлоорой.




Тэгээд **өвгөн** долоон **хүүтэйгээ** **ханаа** дэлгэж, **хаалгаа** босгож, **тооноо** өргөж, **униа** өлгөж, **туургаа** барьж, **дээврээ** тавьж, **бүслүүрээ** татаад, бөмбөрцөг **дэлхийн хэлбэртэй** бөмбөгөр цагаан **гэртэй** болов гэнэ.

Алхам 5: Дараах өгүүлбэрт өгүүлэгдэж байгаа юмсыг заасан жинхэнэ нэр ямар үгтэй холбогдож байгааг тодорхойлоорой.



Тэгээд **өвгөн** долоон **хүүтэйгээ** **ханаа** дэлгэж, **хаалгаа** босгож, **тооноо** өргөж, **униа** өлгөж, **туургаа** барьж, **дээврээ** тавьж, **бүслүүрээ** татаад, бөмбөрцөг **дэлхийн хэлбэртэй** бөмбөгөр цагаан **гэртэй** болов гэнэ.



Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, уنيا өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Алхам 6: Жинхэнэ нэрийн найруулгын үүргийг тайлбарлаарай. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхөж гүйцээгээрэй

Хүүрнэсэн эхийн гол шинж нь үйл явдал нь юмыг заасан буюу, үйлдэл хөдөлгөөн заасан буюу үйл үгийн хослол бүхий өгүүлбэрээр илэрнэ. Тиймээс хүүрнэсэн эхийн утгыг бүтээхэд заан нэрлэж, үйл үгтэй холбогдон, өгүүлбэр буюу үйл явдлыг бүтээж байна.

Жинхэнэ нэрийн тухай онолын ойлголтыг дэвтэртээ бичээрэй.

Үгсийн аймаг

Аливаа хэлний үгсийг үгийн сангийн ерөнхий утга, хэлзүйн онцлог шинжийг харгалзан бүлэглэн хуваасныг үгсийн аймаг гэнэ.

Өгүүлбэрийн бүтцэд орж, төгс утга илэрхийлэхэд ямар нэг үүрэг гүйцэтгэж байгаа бүх үг үгийн аймагт хамаарагдана. Өөрөөр хэлбэл бие даасан утга, үүрэгтэй үгийн сангийн үгээс гадна бие даасан утгагүй боловч өгүүлбэр доторх үгийг холбох үүрэгтэй үгс ч үгийн аймагт хамаарагдана гэсэн үг.

Хүүрнэсэн эхийн үйл явдал: Үйл явдал нь хүн, юм, үзэгдэл түүний хөдлөлөөс бүтсэн өгүүлбэрээр илэрнэ. Үүний хүн, юм гэдэг нь жинхэнэ нэрээр, хөдөлгөөн нь үйл үгээр илэрнэ. Жинхэнэ нэр нь хүүрнэсэн эхэд өгүүлэгдэж байгаа юм болон түлхүүр үгийн үүргээр хэрэглэгдэнэ.

Жинхэнэ нэр: Хүн, юм, үзэгдлийг заан нэрлэж, хэн? юу? хэний? юуны? хэнд? юунд зэрэг асуултад хариулагдах үгсийг хэлнэ.

Жинхэнэ нэрийг утгаар нь оноосон ба ерийн гэж бас ангилна. Оноосон нэрийг ямагт томоор эхэлж бичнэ.